

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарим байгууллагууд
бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт,
үр дүн

АУДИТЫН КОД: ДОА-2025/21-9-ШТА-НА

Чойбалсан хот
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер И.Сэмжидмаа
Утас: 7058-4204, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор Я.Зориг
Утас: 7058-4204, Цахим хаяг: zorigya@audit.gov.mn
Аудитор С.Энхбаатар
Утас: 7058-4204, Цахим хаяг: enkhbaatars@audit.gov.mn
Аудитор М.Ганбилэг
Утас: 7058-4204, Цахим хаяг: ganbilegm@audit.gov.mn
Аудитор Ч.Удвалноров
Утас: 7058-4204, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгт, дүрслэлийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5

БҮЛЭГ А. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарим байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....6

1.1. Хуулийн 8 дугаар зүйл дэх хэрэгжилтийг түүвэрт хамрагдсан байгууллагуудаас төрийн 1 байгууллага хангаж ажиллаагүй байна.....	6-8
1.2. Хэмнэлтийн бусад арга хэмжээг түүвэрт хамрагдсан байгууллагуудаас төрийн 6 байгууллага хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	8-9

БҮЛЭГ Б. Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....10

2.1. Хуулийн 13 дугаар зүйл дэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.....	10-11
2.2. Цахим дэлгүүрээс худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй байна.....	12

БҮЛЭГ В. Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.....13

3.1. Төрийн өмчит компаниуд тус хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.....	13
3.2. Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжсэнээр хэмнэлттэй, үр ашигтай байдлыг тодорхойлох боломжгүй байна.....	13-14
3.3. Төрийн зарим байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....	14-15

ДҮГНЭЛТ:.....	16
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:.....	17
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ:.....	18
ЗӨВЛӨМЖ:.....	18-19
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:.....	20-21

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын стандарт
ДБЭХС	Дорнод бүсийн эрчим хүчний систем
ДОА	Дорнод аймаг
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмчит
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХЦ	Хилийн цэрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ШТА	Шууд тайлагналын аудит
ЭМГ	Эрүүл мэндийн газар
MNS	Mongolian national standard

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Шилэн дансны цахим сайтын зөрчлийн нэгтгэл	14-15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Санал асуулгын дүн – Хуулийн 5 дугаар зүйл	7
Дүрслэл 2	Санал асуулгын үр дүн – Хуулийн 6 дугаар зүйл	7
Дүрслэл 3	Санал асуулгын дүн – Хуулийн 13.1.1 дэх заалтын хэрэгжилт	11
Дүрслэл 4	Санал асуулгын дүн – Хуулийн 13.1.1 дэх заалтыг өөрчлөх санал	11

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” А/107, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаалыг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт	“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэж, уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажилласан уу • Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг хэрэгжүүлж ажилласан уу • Төрийн байгууллагаас хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Дорнод аймгийн 2022, 2023 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлантай уялдуулан, ТЕЗ-ийн харьяа байгууллагууд, зарим ТӨҮГ, ОНӨААТҮГ-ын 2023, 2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрлэн хамруулж, холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, дүн шинжилгээ, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул хянан удирдаж, аудитын менежер И.Сэмжидмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Я.Зориг, аудитор С.Энхбаатар, М.Ганбилэг, Ч.Удвалноров нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын ажлыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэж, тайланг 04 дүгээр сарын 25-ны өдөр Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээ.

БҮЛЭГ А

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зарим байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1. Хуулийн 8 дугаар зүйл дэх хэрэгжилтийг түүвэрт хамрагдсан байгууллагуудаас төрийн 1 байгууллага хангаж ажиллаагүй байна.

Аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5-12 дугаар зүйлийн хэрэгжилтэд аудитын горим сорил хэрэгжүүлж, нийт 20 байгууллагыг түүвэрлэн 2023-2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4¹-д заасны дагуу төсвийн шууд, төвлөрүүлэн захирагчид, төрийн болон орон нутгийн өмчит газруудын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 32 байгууллагад бүртгэлтэй тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх талаар зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулсан байна.

2. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1²-д заасны дагуу улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр захиргааны зориулалтаар шинээр барилга баригдаагүй байна.

3. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1³, 8.2⁴ дахь заалтыг зөрчиж аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2024 оны эцэст нэмэлт данснаас ажилтнууддаа ажлын костюм захиалгаар хийлгүүлж худалдан авахад 8,797,300.0 төгрөгийг зарцуулсан байна.

4. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁵-д заасны дагуу томилолтоор ажиллахдаа агаарын тээврийн хэрэгслээр энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчсон тохиолдол гараагүй байна.

5. Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу орон нутгийн өмчит газруудын албан хаагчдын цалинг Засгийн газрын жишиг тогтоолын дагуу тогтоосон байна.

6. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1⁶-д заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг давхардуулан олгосон тохиолдол гараагүй байна.

¹ 6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

² 7.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно.

³ 8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно

⁴ 8.2. Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.

⁵ 9.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно.


⁶ 11.1.Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.

7. Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагуудаас 12 дугаар зүйлийн 12.1⁷-ийн 12.1.1⁸, 12.1.3⁹-д заасан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөрийг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх санал асуулгад түүвэрт хамрагдсан 20 байгууллага, сумдын Засаг даргын Тамгын газрын 14, нийт 40 удирдах албан тушаалтан, санхүүгийн албан хаагчдыг хамрууллаа. Санал асуулгаар төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад хууль хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл, бэрхшээл үүсгэж болох анхаарал татахуйц зүйл заалтын талаар асууж тодруулахад дараах үр дүнг үзүүлсэн байна.

Санал асуулгын асуулт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд, орлогч дарга, зөвлөх зэрэг албан тушаалтан ажиллуулахыг хязгаарласан заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна уу?


Дүрслэл 1. “Санал асуулгын дүн – Хуулийн 5 дугаар зүйл”



Санал асуулгын үр дүнгээс үзэхэд, оролцогчдын **15.4 хувь** нь хуулийн 5 дугаар зүйлд өөрчлөлт оруулах шаардлагатай, харин **84.6 хувь** нь шаардлагагүй гэж хариулсан байна.

Санал асуулгын асуулт: Хуулийн 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл ашиглахыг хязгаарлаж байгаа нь танай байгууллагын үйл ажиллагаа явуулахад хүндрэл, бэрхшээл үүсгэж байна уу?

Дүрслэл 2. “Санал асуулгын үр дүн – Хуулийн 6 дугаар зүйл”



Санал асуулгын үр дүнгээс үзэхэд, хуулийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх явцад хүндрэл, бэрхшээл үүсэж байгаа эсэх талаар асуухад оролцогчдын **40 хувь** нь “үгүй”, **32.5 хувь** нь “тийм” гэж хариулсан бол үлдсэн **27.5 хувь** нь уг хязгаарлалтад хамаарахгүй байгууллагууд хамрагдсан байна.

⁷ 12.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:

⁸ 12.1.1.үндсэн үйл ажиллагаа нь шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй этгээдийн албаны гар утасны зардлаас бусад гар утасны зардал;

⁹ 12.1.3.хэвлэлийн захиалгын төлбөр;

Дүгнэлт: Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилоор хуулийн 8 дугаар зүйл дэх “дүрэмт хувцас” худалдан авахыг хязгаарласан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн 1 байгууллага байгаа бол бусад 19 байгууллагад хуулийн 5-12 дахь заалтын хэрэгжилт хангалттай хэмжээнд буюу зөрчил гаргаагүй ажилласан байна.

1.2. Хэмнэлтийн бусад арга хэмжээг төрийн 6 байгууллага хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын хувьд аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээг мөрдөж ажилласан эсэхэд аудитын горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн ЗДТГ нь 2023 онд 478,000.0 төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл болох 5 ширхэг цом хийлгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.” 15.1.5¹⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2023 онд 210,000.0 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлд нэрмэл архийг оролцуулан худалдан авсан байна.

- Хэрлэн сумын ЗДТГ нь Чойбалсан хотын “Алдар гавьяаны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 2023 онд зочин, төлөөлөгчдийн хүлээн авалтын согтууруулах ундаанд 1,380,000.0 төгрөгийг зарцуулсан байна.

- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь 2024 онд 203,100.0 төгрөгийн үнэ бүхий бэлэг дурсгал, согтууруулах ундааны зүйл худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.” 15.1.5¹¹, 15.1.7¹² дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

- Чойбалсан нисэх буудал 2023 онд нээлттэй хаалганы өдрөөр байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор танилцуулга, нэвтрүүлэг, мэдээ бэлтгэхэд зориулж 2,290,000.0 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-ийн “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно.” 15.1.4¹³ дэх заалтыг зөрчсөн байна.

Хэрлэн сумын 10 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 2023 онд, тус цэцэрлэгийн эрхлэгчид ямар нэгэн тушаал, шийдвэргүйгээр үндсэн цалингийн 20 хувьтай тэнцэх хэмжээний буюу 236,500.0 төгрөгийн урамшуулал олгосон байна.

¹⁰ 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

¹¹ 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

¹² 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах.

¹³ 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;

- Төсвийн шууд захирагч нарын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт боловсрол, эрүүл мэндийн салбарын 70 байгууллагад 244.3 сая төгрөгийн албан шаардлага өгч, биелэлтийг хангуулж ажилласан.
- Харин 2024 онд, цэцэрлэгийн нягтлан бодогч болон нярав нарт санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан гэх үндэслэлээр улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/48 дугаар тушаалаар нийт 2,096,200.0 төгрөг олгосон байна.
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн шагнал олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3-т “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц түвэгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж, хэрэглээнд нэвтрүүлсэн тохиолдолд олгоно” гэж заасан шаардлагыг хангаагүй байхад 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/48 дугаар тушаалаар нийт 27 албан хаагчид цалин сангаас 12,773,950.0 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3¹⁴, 15.2.6¹⁵ дахь хориглосон заалтыг зөрчсөн байна.

Хэмнэлтийн бусад арга хэмжээний хориглосон заалтыг зөрчиж байгууллагын төсвөөс санхүүжилт гаргасан дээрх тохиолдлуудад 26,368,850.0 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 2,096,200.0 төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Дүгнэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь заалтуудыг зөрчсөн нийт 28,456,050.0 төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, албан шаардлага өгч, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар төсөв захирагч нар анхаарч ажиллах шаардлагатай байна.

¹⁴ 15.1.3. Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

¹⁵ 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.

БҮЛЭГ Б

Хөрөнгө оруулалттай холбоотой хуульд заасан журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1. Хуулийн 13 дугаар зүйл дэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл дэх “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ”-ний зарим заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хөдөө аж ахуйн сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх “Арван мянган хүлэмж” төслийн хүрээнд 410 ширхэг хүлэмжийг 709.2 сая төгрөгөөр худалдан авч 14 сумын иргэн, хоршоололд тараан олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-ийн “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно.” 13.3.2 дахь “Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ” заалтыг зөрчиж, тухайн зөрчилд Төрийн аудитын байгууллагаас төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

2. “Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан”-д хийсэн аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ Матад, Баян-Уул, Баянтүмэн, Дашбалбар сумд иргэдээс санал аваагүй 4,550.3 сая төгрөгийн 39 төсөл арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.” гэсэн заалтыг зөрчиж, тухайн зөрчилд албан шаардлага өгч ажилласан байна.

3. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитаар Баяндун, Баянтүмэн, Баян-Уул, Булган, Гурванзагал, Дашбалбар, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан, Чулуунхороот сумд иргэдийн санал аваагүй 1940.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.


Хуулийн 13.1, 13.2, 13.3, 13.5, 13.6 дахь заалтын хэрэгжилтийг “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-нд хийх гүйцэтгэл, нийцлийн аудитуудаар дэлгэрэнгүй авч үзнэ.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах,” заалт нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжихээр байна.

Дээрх заалтын хэрэгжилттэй холбоотой санал асуулгын дүнг авч үзвэл:

Санал асуулгын асуулт: Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэж байна уу?

Дүрслэл 3. "Санал асуулгын дүн – Хуулийн 13.1.1 дэх заалтын хэрэгжилт"



Санал асуулгын дүнгээс үзэхэд, хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх явцад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх тухай асуултад оролцогчдын **55 хувь** нь "үгүй", харин **45 хувь** нь "тийм" гэж хариулсан байна.

Санал асуулгын асуулт: Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтад өөрчлөлт оруулбал хэрхэн өөрчлөлтийг тусгах вэ?

Дүрслэл 4. "Санал асуулгын дүн – Хуулийн 13.1.1 дэх заалтыг өөрчлөх санал"



Санал асуулгын үр дүнд, хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг өөрчлөх шаардлагын талаар асуултад оролцогчдын **64.1 хувь** нь "Хэрэгжүүлэх хугацааг сунгах байдлаар өөрчлөн найруулах", харин **15.4 хувь** нь "Тус заалтыг бүрмөсөн хасаж найруулах" гэж санал өгсөн байна.

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх явцад хуулийн хязгаарлалт, хориглох заалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй боловч хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хугацааны хувьд хүндрэл, бэрхшээл үүсгэж, үүнээс шалтгаалан тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж амжихгүй байх эрсдэл үүсдэг тул тухайн заалтыг хасах, өөрчлөн найруулах саналыг санал асуулгад оролцогчдын 79.5 хувь нь үзсэн байна.

2.2. Цахим дэлгүүрээс худалдан авах ажиллагааг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан 20 байгууллагуудаас 2023-2024 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүн нь зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний бодит үнээс зөрүүтэй буюу үнэтэй, худалдан авагчийн тавьсан шаардлагад нийцэхгүй байгаатай холбоотой байна.

Дүгнэлт: Цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад орчин нөхцөл хангалттай хэмжээнд бүрдээгүй учраас худалдан авагч байгууллагуудаас хуулийн тус заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүссэн байна. Тухайлбал цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний сонголт муу, үнэтэй, хэрэглэгчдийн тавьсан шаардлагад нийцэхгүй байна.

БҮЛЭГ В

Төрийн байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай байна.

3.1. Төрийн өмчит компаниуд тус хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана.” гэж заасан.

Төрийн аудитын газраас МУЕА-ын 2022 оны А/89 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг мөрдөж, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022-2024 онуудын санхүүгийн тайланд аудит хийх явцад горим, сорилыг хэрэгжүүлж, улмаар 703.8 сая төгрөгийн зөрчилд акт, албан шаардлага, зөвлөмж өгч, биелэлтийг хангуулсан байна.

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу аудитад хамрагдсан “ДБЭХС” ТӨХК, Чойбалсан нисэх буудал ТӨХК-ууд нь тус заалтад хяналт тавьж, хэрэгжүүлээгүй байна.

Дүгнэлт: Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын хэрэгжилт орон нутагт хэрэгжихгүй байгаа тул төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд тус заалтад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

3.2. Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжсэнээр хэмнэлттэй, үр ашигтай байдлыг тодорхойлох боломжгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлснээр төсвийн зардлыг хязгаарлаж, илүү оновчтой, үр ашигтай зарцуулалт хийх боломж бүрдсэн ч зарим байгууллагад хэрэгжилт жигд бус, үр дүн нь мэдрэгдэхгүй байх тул тодорхойлох боломжгүй байна.

Аймгийн ЗДТГ нь 2021-2025 онд “Гинжит өртөө” ХХК-тай гэрээ байгуулж, хамтарч ажиллажээ. Ингэхдээ 2021-2022 онуудад тус компанид аймгийн ЗДТГ-аас өөр бусад газраас орлогын гүйлгээ хийгдээгүй, 2021-2024 онуудад жилийн орлого нь дунджаар 49.5 сая төгрөгийн борлуулалттай ажилласан ба 50.0 сая төгрөгөөс дээш давсан орлогыг захирал нь хувийн дансанд шилжүүлэн авчээ. Энэ нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагыг татвараас зайлсхийсэн байж болзошгүй гэж дүгнэхээр байна.

Иймд “Гинжит өртөө” ХХК-ийн 2021-2024 оны борлуулалтын орлогод татвар ногдуулах асуудлыг Татварын газарт шилжүүлэхээр шийдвэрлэв.

Цаашид аймгийн ЗДТГ нь бичиг хэрэг, ахуйн хэрэглээ, бараа материалын төсвийг зарцуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-д заасны дагуу хууль журамд нийцүүлэн худалдан авахдаа худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй, бусад ААНБ-ууд оролцох боломжтой байдлаар зохион байгуулж, шалгарсан ААН-тэй гэрээ байгуулж ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөвт байгууллагын төсвийн зардлыг хязгаарлаж, илүү оновчтой, үр ашигтай зарцуулалт хийх боломж бүрдсэн хэдий ч зарим байгууллагад хэрэгжилт жигд бус, үр дүн нь мэдэгдэхгүй байгаа тул хэмнэлт, үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.

3.3. Төрийн зарим байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цахим хуудаст хугацаанд нь байршуулж, мэдээлээгүй дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Хүснэгт 1. “Шилэн дансны цахим сайтын зөрчлийн нэгтгэл”

№	Байгууллагын нэр	Хоцроосон мэдээллийн тоо	Огт байршуулаагүй мэдээллийн тоо	Товч утга
1	ХЦ-ийн 0132-р анги	1	-	2024 он – Батлагдсан төсөв
2	Хан-Уул цогцолбор сургууль	-	1	2023 он - Хандив тусламжийн орлогын тайлан. Хандив тусламжийн орлого 36,766,838.0 төгрөг байна.
3	Аймгийн ЗДТГ	1	1	- 2023 он - Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байршуулаагүй, - 2024 он - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроосон.
4	Онцгой байдлын газар	3	-	- 2023 он - Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, - 2024 он – Хөтөлбөр, зориулалт /4-р сар/, Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал /4-р сар/
5	ДБЭХС ТӨХК	4	-	- 2023 он - Дараа жилийн зорилтот түвшин, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, - 2024 он - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Худалдан авах ажиллагааны тайлан
6	Хэрлэн сумын ИТХ	2	2	- 2023 он - Санхүүгийн хагас жилийн тайлан, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроосон. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг огт мэдээлээгүй.
7	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	1	-	- 2024 он - Дараа жилийн төсвийн төсөл
8	ХХҮГ	10	2	- 2023 он – 1. Хөтөлбөр, зориулалт /7-р сар/, 2. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /7-р сар/, 3. Хагас жилийн санхүүгийн тайлан, 4. Дараа жилийн төсвийн төсөл, 5. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 6. Худалдан авах ажиллагааны тайлан, 7. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож, 8. Жилийн эцсийн санхүүгийн тайлан, 9. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг огт мэдээлээгүй. - 2024 он – 1. Хагас жилийн санхүүгийн тайлан, 2. Байгууллагын батлагдсан төсөв, 3. Аудитын тайлан,

				дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроосон.
9	Хэрлэн сумын 5-р цэцэрлэг	12	-	2024 он – Батлагдсан төсөв, гүйцэтгэл – хөтөлбөр, зориулалт /5,6,8-р сар/, Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал /5,6,8-р сар/, Батлагдсан төсөв, Дараа жилийн төсвийн төсөл, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт /5,6,8-р сар/ зэрэг 12 мэдээллийг хоцроосон.
10	Чойбалсан нисэх буудал	4	-	2023, 2024 онд нийт 4 мэдээллийг хоцроосон.
11	Аймгийн ИТХ	4	-	2023, 2024 онд нийт 4 мэдээллийг хоцроосон.
12	ЭМГ	4	-	2023 онд 1, 2024 онд 3 мэдээллийг хоцроосон.
	НИЙТ	46	6	

Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудас www.shilendans.gov.mn

Аудитын түүвэрт хамрагдсан 20 байгууллагаас хүснэгт 1-д дурдсан өрийн байгууллагууд нь хуулийн хугацаанд байршуулах төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроох болон огт байршуулаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Дүгнэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг Хүснэгт 1-д дурдсан төрийн байгууллагууд бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Иймд хуулийн хугацаанд иргэд, олон нийтэд байгууллагын төсөв, санхүүгийн талаарх мэдээллийг ил тод, нээлтэй, үнэн зөв мэдээлэх үүргээ хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим, сорил, цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь “дүрэмт хувцас” худалдан авахыг хязгаарласан заалтыг түүвэрт хамрагдсан 20 байгууллагаас хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн 1 байгууллага байгаа бол бусад 19 байгууллагад хуулийн 5-12 дахь заалтын хэрэгжилт хангалттай хэмжээнд буюу зөрчил гаргаагүй ажилласан байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7 дахь хориглосон заалтуудыг зөрчсөн нийт 28,465.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгаж, барагдуулах талаар төлбөрийн акт, албан шаардлага өгч, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар төсөв захирагч нар анхаарч ажиллах шаардлагатай байна.
3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх явцад хуулийн хязгаарлалт, хориглох заалттай холбоотой алдаа, зөрчил илрээгүй боловч хуулийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хугацааны хувьд хүндрэл, бэрхшээл үүсгэж, үүнээс шалтгаалан тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж амжихгүй байх эрсдэл үүсдэг тул тухайн заалтыг хасах, өөрчлөн найруулах саналыг санал асуулгад оролцогчдын 79.5 хувь нь үзсэн байна.
4. Цахим дэлгүүрээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад орчин нөхцөл хангалттай хэмжээнд бүрдээгүйн улмаас худалдан авагч байгууллагуудаас хуулийн тус заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүссэн байна. Тухайлбал цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний сонголт муу, үнэтэй, хэрэглэгчдийн тавьсан шаардлагад нийцэхгүй байна.
5. Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2¹⁶ дахь заалт орон нутагт хэрэгжихгүй байгаа тул төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд тус заалтад хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнээр төсөвт байгууллагын төсвийн зардлыг хязгаарлаж, илүү оновчтой, үр ашигтай зарцуулалт хийх боломж бүрдсэн хэдий ч зарим байгууллагад хэрэгжилт жигд бус, үр дүн нь мэдэгдэхгүй байгаа тул хэмнэлт, үр ашгийг тодорхойлох боломжгүй байна.
7. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг *Хүснэгт 1*-д дурдсан төрийн 12 байгууллага шилэн дансны цахим хуудастаа 6 мэдээллийг огт байршуулаагүй, 46 мэдээллийг 2023-2024 онд хугацаа хоцроож байршуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна.” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹⁶ 19.2. Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, ТАЙЛБАР:

417



ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-3040, факс: 7058-4681
Цахим шуудан: azdtg@dornod.gov.mn
Цахим хуудас: Dornod.gov.mn

2025.04.22 № 2/981

таний -ны № -т

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн хариуг
хүргүүлж байна.

1 дүгээр асуудлын хүрээнд: Төрийн
хэмнэлтийн хуулийг цаашид хэрэгжүүлж ажиллана.

2 дугаар асуудлын хүрээнд: Хэд хэдэн
байгууллага, аж ахуйн нэгжээс үнийн санал авч
хэмнэлтийн хуулинд тохирсон хамгийн бага үнийн
саналтай "Гинжит Өртөө" ХХК-тай гэрээ байгуулан
ажиллаж байна.

3 дугаар асуудлын хүрээнд: Цаашид Шилэн
дансны хуулийн хэрэгжилтийг хэрэгжүүлж
ажиллана.

ДАРГА  П.БАТ-ӨЛЗИЙ



215080501

Бичиг 2/22

Саналд өгсөн тайлбар:

Аймгийн ЗДТГ-ын даргын 2025.04.22-ны өдрийн 2/981 дүгээр албан бичгээр ирүүлсэн тайлбарын 2 дахь хэсэгт тайлангийн нөхцөл байдалтай холбоотой тайлбар ирүүлээгүй тул тухайн асуудлын аймгийн Татварын газарт шилжүүлж шийдвэрлүүлэхээр шийдвэрлэ.

ҮАГ-ААР ДАМЖУУЛАН ХОЛБОГДОХ ГАЗРУУДАД УЛАМЖЛАХ САНАЛ:

1. Цахим дэлгүүрийн бараа, бүтээгдэхүүний нэр төрөлд хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн баяжилт хийх, зах зээл дээрх бараа, бүтээгдэхүүний үнэд судалгаа хийх замаар үнийн бодлогод өөрчлөлт оруулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт уламжлах.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд хугацааны хувьд хүндрэл, бэрхшээл үүсгэж, үүнээс шалтгаалан тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж амжихгүй байх эрсдэл үүсгэж байгаа талаар аймгийн ЗДТГ, сумдын ЗДТГ-ын төсвийн шууд захирагч нараас аудитын явцад саналууд ирсэн тул хуулийн тус заалтад өөрчлөлт оруулах саналыг УИХ-д уламжлах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах төсөв захирагч нарт зөвлөж байна. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын дарга П.Бат-Өлзийд:

1. Цаашид батлагдсан төсөвт өртөг нь 20.0 сая төгрөгөөс доош бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ын 35 дугаар зүйлд заасны дагуу гэрээ шууд байгуулах аргыг ашиглах.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг тухай бүрд нь цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах.

2. ДБЭХС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг үйл ажиллагаанд мөрдлөг болгож, хуульд заасан хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлэх.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг тухай бүрд нь цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах.

3. Чойбалсан нисэх буудлын дарга С.Батхүү:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг үйл ажиллагаанд мөрдлөг болгож, хуульд заасан хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлэх.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг тухай бүрд нь цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах.

4. Аймгийн ИТХ, ЭМГ, ХХҮГ, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Хэрлэн сумын ИТХ, 5-р цэцэрлэг, Хан-Уул цогцолбор сургууль, ХЦ-ийн 0132-р анги, Онцгой байдлын газрын дарга, захирал, эрхлэгч нарт:

1. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг цаг тухай бүрд нь цахим хуудаст байршуулж, иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангаж ажиллах, мэдээллийг хуулийн хугацаанаас хоцроохгүй байх, байршуулаагүй

мэдээллийг нөхөж байршуулах. /Тайлангийн 12-13-р хуудас, хүснэгт 1 дэх мэдээллээс тус тусын байгууллагын мэдээлэлтэй танилцах/

Аудитаар нийт 65,231.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 26,368.9 мянган төгрөгийн 8 төлбөрийн акт, 2,096.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 36,766.8 мянган төгрөгийн зөрчилд 15 зөвлөмж өгч ажиллан Үндэсний аудитын газарт 2 саналыг уламжиллаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2025 оны 11 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Анхаарах зүйл: Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг **аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 03 өдөр


Дугаар А/19

Чойбалсан хот

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар болон аудитад хамрагдсан бусад байгууллагад тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Я.Зориг)-т даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

2125010030

Тэргүүлэх аудиторын 2025 оны
05 дугаар сарын 02-ны өдрийн
А/19 дүгээр тушаалын хэвсрэлт



Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	ДОА-2025/21- 9-ШТА-НА	Төлбөр барагдуулах тухай	8,797,300
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар		Төлбөр барагдуулах тухай	203,100
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар		Төлбөр барагдуулах тухай	478,000
4	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		Төлбөр барагдуулах тухай	210,000
5	Чойбалсан нисэх буудал		Төлбөр барагдуулах тухай	2,290,000
6	Хэрлэн сумын ЗДТГ		Төлбөр барагдуулах тухай	1,380,000
7	Хэрлэн сумын 10-р цэцэрлэг		Төлбөр барагдуулах тухай	236,500
8	Хэрлэн сумын 10-р цэцэрлэг		Төлбөр барагдуулах тухай	12,773,950
	Нийт дүн			26,368,850

Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр, албан тушаал	Гүйцэтгэлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлагын утга	Мөнгөн дүн /төгрөгөөр/
1	Хэрлэн сумын 10-р цэцэрлэг	ДОА-2025/21- 9-ШТА-НА	Зөрчил арилгах тухай	2,096,200
	Нийт дүн			2,096,200

---oOo---

